



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ойн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/409/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: **Ц.Наранчимэг**
Утас: 51-261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: **Э.Энхбаатар**
Утас: 51-260512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn
Ахлах аудитор: **Г.Мөнхчимэг**
Утас: 51-261628 Цахим хаяг: Munkhchimegg@audit.gov.mn
Аудитор: **Ч.Мөнхбулган**
Утас: 51-261628 Цахим хаяг: Munkhbulganch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ОЙН ГАЗРЫН ДАРГА
Б.ОЮУНСАНАА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.08.25 № 07/676

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ойн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Ойжуулалт хөтөлбөрийн болон Афоко төслөөс гэрээгээр гүйцэтгэсэн ажлын чанарын баталгааны нийт 204,047.8 мянган төгрөгийн барьцааг суутгаагүй, санхүүжилтийг бүрэн олгосон;
- Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогоор 3 нэр төрлийн 81,886.9 мянган төгрөгийн хөрөнгө биетээр оршин байхгүй байсан;
- Мод тарьж, арчлан ургуулах чиглэлээр 1000 сургагч багш бэлтгэх ажлын хүрээнд тайлант онд 498 иргэнийг сургагч багшаар бэлтгэх 195,902.2 мянган төгрөгийн төсөв баталж, шууд гэрээ байгуулсан ба сургагч багш бэлтгэснээр гарах үр дүн хэрэгжилт хангалтгүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Ойжуулалт хөтөлбөрийн 2024 онд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 549,500.0 мянган төгрөгийн төсөвтэй Ой модны салбарын 100 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээг баталж, гүйцэтгэлээр 425,224.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

“Ойжуулалт” хөтөлбөр арга хэмжээнд 43,985,540.6 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 43,570,645.3 мянган төгрөгийг зарцуулж, 494,409.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамаараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,622,659,824.70	4,880,518,445.46
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	20,934,008.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	20,934,008.00
33	АВЛАГА	369,294,896.70	324,893,202.06
33300	Татаас, санхүүжилтийн авлага	369,294,896.70	324,893,202.06
35	БАРАА МАТЕРИАЛ	2,253,364,928.00	4,534,691,235.40
35100	Түүхий эд материал	1,643,824,715.00	3,736,237,209.40
35110	Тусгай зориулалттай материал	1,643,824,715.00	3,736,237,209.40
35400	Хангамжийн материал	609,540,213.00	798,454,026.00
35410	Бичиг хэргийн материал	4,776,500.00	3,628,000.00
35420	Аж ахуйн материал	58,971,200.00	243,968,680.00
35440	Түлш, шатах тослох материал	-	3,071,611.00
35470	Бусад хангамжийн материал	545,792,513.00	547,785,735.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,063,640,940.10	14,261,503,390.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,063,640,940.10	14,261,503,390.76
39200	Биет хөрөнгө	1,834,664,490.00	8,058,242,994.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	699,670,430.00	4,352,099,953.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(258,338,758.11)	(366,074,614.23)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,289,775,873.50	2,480,052,935.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,916,599,566.04)	(1,694,784,188.32)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,688,178,569.96	1,659,852,908.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,080,123,834.22)	(642,026,642.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,034,676.80	72,566,916.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	(52,054,780.44)	(33,519,668.97)
39209	Зам, гүүрийн байгууламж	-	1,887,380,953.26
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(29,214,249.78)
39214	Бусад үндсэн хөрөнгө	637,587,468.50	646,542,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(231,465,589.95)	(274,634,108.38)
39300	Биет бус хөрөнгө	6,228,976,450.07	6,203,260,396.20
39301	Программ хангамж	90,868,962.00	73,664,895.33
39302	Хуримтлагдсан элэгдэл	(24,496,845.28)	(30,010,499.16)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,168,601,000.00	6,168,601,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(5,996,666.65)	(8,994,999.97)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,686,300,764.77	19,142,021,836.22
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	20,934,008.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	20,934,008.00
41300	Өглөг	-	20,934,008.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,686,300,764.77	19,121,087,828.22
51	Засгийн газрын хувь оролцоо	10,686,300,764.77	19,121,087,828.22
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,696,476,268.14	6,696,476,268.14
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	6,696,476,268.14	6,696,476,268.14
51200	Хуримтлагдсан үр дүн	3,914,997,243.44	12,349,784,306.89
51210	Өмнөх үеийн үр дүн	3,245,799,354.77	4,072,342,243.44
51220	Тайлант үеийн үр дүн	669,197,888.67	8,277,442,063.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74,827,253.19	74,827,253.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,686,300,764.77	19,142,021,836.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	17,325,031,981.20	55,088,833,010.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	860,653,874.50	5,949,753,219.54
120	Нийтлэг татварын бус орлого	860,653,874.50	5,949,753,219.54
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	860,653,874.50	5,949,753,219.54
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	20,235,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	309,539,896.50	5,924,446,408.54
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	551,113,978.00	4,063,958.00
120009	Бусад орлого	-	1,007,853.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,464,378,106.70	49,139,079,791.15
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	16,094,425,227.00	46,364,500,755.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,723,142,500.00	46,364,500,755.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	371,282,727.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	369,952,879.70	2,774,579,036.15
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	369,294,896.70	2,720,497,237.15
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	657,983.00	54,081,799.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	16,655,834,092.53	44,314,759,846.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,655,834,092.53	44,314,759,846.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,600,486,869.87	43,768,254,483.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	896,295,814.31	1,641,364,656.89
210101	Үндсэн цалин	528,370,461.02	999,004,944.82
210102	Нэмэгдэл	143,300,009.11	197,706,209.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	124,248,065.42	188,157,186.40
210104	Урамшуулал	66,564,479.70	114,889,366.05
210105	Гэрээт ажлын хөлс	33,812,799.06	141,606,950.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,670,011.63	212,609,092.03
210201	Тэтгэврийн даатгал	76,937,516.34	156,450,586.59
210202	Тэтгэмжийн даатгал	9,041,443.27	14,888,124.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,193,554.46	7,605,502.45
210204	Ажилгүйдлийн даатгал	1,772,499.26	7,209,615.71
210205	Эрүүл мэндийн даатгал	17,724,998.30	26,455,263.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,659,650.38	67,530,075.45
210301	Гэрэл, цахилгаан	3,060,030.38	6,330,075.45
210302	Түлш, халаалт	2,539,200.00	-
210304	Байрны түрээс	42,060,420.00	61,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	304,418,996.51	387,817,854.95
210401	Бичиг хэрэг	25,797,395.00	50,641,602.00
210402	Тээвэр, шатахуун	120,281,675.00	178,987,265.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,811,239.51	13,787,242.95
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	495,000.00	2,700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,850,000.00	76,120,665.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	12,107,200.00	65,581,080.00
210408	Бараа материал акталсны зардал	134,076,487.00	-
2105	Нормативд зардал	-	5,043,390.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	5,043,390.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,270,650.00	81,697,930.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,408,000.00	4,945,500.00

210604	Урсгал засвар	37,862,650.00	76,752,430.00
2107	Томилолт, зочны зардал	129,760,000.00	337,243,440.00
2101701	Гадаад албан томилолт	-	31,755,440.00
210702	Дотоод албан томилолт	129,760,000.00	305,488,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,384,124,966.65	40,376,004,125.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,375,048,916.40	40,349,896,593.80
210803	Даатгалын үйлчилгээ	7,875,489.00	11,219,667.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	675,561.25	1,619,965.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	6,842,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	525,000.00	6,425,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	673,286,780.39	658,943,917.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,071,200.00	2,713,460.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,820,000.00	49,714,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	658,395,580.39	606,516,057.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,055,347,222.66	546,505,363.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,777,890.00	48,351,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,708,000.00	18,351,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,069,890.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	30,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,025,569,332.66	498,154,363.57
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,024,911,349.66	498,154,363.57
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	657,983.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	669,197,888.67	10,774,073,164.05
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,496,631,100.60
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал- Бараа материал	-	2,946,631,100.60
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (IV)=(145-225)	-	(2,496,631,100.60)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	669,197,888.67	8,277,442,063.45

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	16,464,378,106.70	49,661,008,803.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	152,634,116.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	152,634,116.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	20,235,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	20,235,000.00
120009	Бусад орлого	-	132,399,116.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,464,378,106.70	49,508,374,687.85
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	16,094,425,227.00	46,364,500,755.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,723,142,500.00	46,364,500,755.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	371,282,727.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	369,952,879.70	3,143,873,932.85
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	369,294,896.70	3,089,792,133.85
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	657,983.00	54,081,799.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,823,262,171.84	47,031,990,750.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,823,262,171.84	47,031,990,750.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,398,620,052.48	46,160,592,185.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	896,295,814.31	1,641,364,656.89
210101	Үндсэн цалин	528,370,461.02	999,004,944.82
210102	Нэмэгдэл	143,300,009.11	197,706,209.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	124,248,065.42	188,157,186.40
210104	Урамшуулал	66,564,479.70	114,889,366.05
210105	Гэрээт ажлын хөлс	33,812,799.06	141,606,950.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,670,011.63	212,609,092.03
210201	Тэтгэврийн даатгал	76,937,516.34	156,450,586.59
210202	Тэтгэмжийн даатгал	9,041,443.27	14,888,124.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,193,554.46	7,605,502.45
210204	Ажилгүйдлийн даатгал	1,772,499.26	7,209,615.71
210205	Эрүүл мэндийн даатгал	17,724,998.30	26,455,263.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,120,450.38	67,530,075.45
210301	Гэрэл, цахилгаан	3,060,030.38	6,330,075.45
210304	Байрны түрээс	42,060,420.00	61,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	116,704,639.51	201,835,372.95
210401	Бичиг хэрэг	8,121,200.00	16,512,295.00
210402	Тээвэр, шатахуун	80,152,000.00	155,635,418.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,811,239.51	13,787,242.95
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	495,000.00	2,700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,125,200.00	13,200,417.00
2105	Нормативд зардал	3,671,600.00	14,561,390.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,671,600.00	14,561,390.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,939,100.00	99,448,780.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,777,300.00	15,686,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,135,000.00	4,132,950.00
210604	Урсгал засвар	51,026,800.00	79,629,230.00
2107	Томилолт, зочны зардал	129,760,000.00	337,793,440.00
210701	Гадаад албан томилолт	-	31,755,440.00
210702	Дотоод албан томилолт	129,760,000.00	306,038,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,013,329,636.65	43,529,820,017.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,003,047,694.40	43,503,712,485.80
210803	Даатгалын үйлчилгээ	7,875,489.00	11,219,667.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	675,561.25	1,619,965.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	6,842,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,730,892.00	6,425,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,128,800.00	55,629,360.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,308,800.00	4,798,460.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,820,000.00	50,830,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,424,642,119.36	871,398,565.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,777,890.00	48,351,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,708,000.00	18,351,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,069,890.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	30,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,394,864,229.36	823,047,565.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,024,911,349.66	823,047,565.63
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	369,952,879.70	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	641,115,934.86	2,629,018,053.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	641,115,934.86	2,497,626,790.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	641,115,934.86	2,497,626,790.00
2200	Дотоод эх үүсвэрээр	641,115,934.86	2,497,626,790.00
220001	Барилга байгууламж	371,282,727.00	-
222001	Тоног төхөөрөмж	-	1,617,694,690.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	269,833,207.86	879,932,100.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(641,115,934.86)	(2,497,626,790.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	110,457,255.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	110,457,255.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(110,457,255.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	20,934,008.00
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20,934,008.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	3,245,799,354.77	10,017,102,876.10
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	3,245,799,354.77	10,017,102,876.10
Тайлант үеийн үр дүн	-	-	669,197,888.67	669,197,888.67
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	3,914,997,243.44	10,686,300,764.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	157,345,000.00	157,345,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	4,072,342,243.44	10,843,645,764.77
Тайлант үеийн үр дүн	-	-	8,277,442,063.45	8,277,442,063.45
2024 оны 12-р сарын 31-нээр үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	12,349,784,306.89	19,121,087,828.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,572,159,700.00	45,891,334,243.43	680,825,456.57	99.0
УРСГАЛ ЗАРДАЛ	46,572,159,700.00	45,891,334,243.43	680,825,456.57	99.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,552,543,900.00	45,872,983,243.43	679,560,656.57	99.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,568,620,500.00	1,384,621,838.22	183,998,661.78	88.0
Үндсэн цалин	744,967,400.00	742,262,126.15	2,705,273.85	100.0
Нэмэгдэл	198,605,100.00	197,706,209.11	898,890.89	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	194,275,200.00	188,157,186.40	6,118,013.60	97.0
Урамшуулал	125,459,500.00	114,889,366.05	10,570,133.95	92.0
Гэрээт ажлын хөлс	305,313,300.00	141,606,950.51	163,706,349.49	46.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	192,827,800.00	183,233,265.91	9,594,534.09	95.0
Тэтгэврийн даатгал	131,122,900.00	127,074,760.47	4,048,139.53	97.0
Тэтгэмжийн даатгал	15,426,100.00	14,888,124.07	537,975.93	97.0
ҮОМШӨ-ний даатгал	7,713,100.00	7,605,502.45	107,597.55	99.0
Ажилгүйдлийн даатгал	7,713,100.00	7,209,615.71	503,484.29	93.0
Эрүүл мэндийн даатгал	30,852,600.00	26,455,263.21	4,397,336.79	86.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,801,000.00	52,410,075.45	2,390,924.55	96.0
Гэрэл, цахилгаан	7,908,600.00	6,330,075.45	1,578,524.55	80.0
Байрны түрээс	46,892,400.00	46,080,000.00	812,400.00	98.0
Хангамж, бараа материалын зардал	209,482,300.00	159,783,174.95	49,699,125.05	76.0
Бичиг хэрэг	10,897,600.00	10,854,370.00	43,230.00	100.0
Тээвэр, шатахуун	177,772,300.00	128,339,076.00	49,433,224.00	72.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,088,300.00	7,908,648.95	179,651.05	98.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,737,200.00	2,700,000.00	37,200.00	99.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,986,900.00	9,981,080.00	5,820.00	100.0
Нормативд зардал	13,273,200.00	9,518,000.00	3,755,200.00	72.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,273,200.00	9,518,000.00	3,755,200.00	72.0
Эд хогшил, урсгал засварын зардал	167,817,600.00	163,820,580.00	3,997,020.00	98.0
Багаж, техник, хэрэгсэл	81,723,400.00	80,058,400.00	1,665,000.00	98.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,136,200.00	4,132,950.00	3,250.00	100.0
Урсгал засвар	81,958,000.00	79,629,230.00	2,328,770.00	97.0
Томилолт, зочны зардал	247,268,600.00	241,516,000.00	5,752,600.00	98.0
Дотоод албан томилолт	247,268,600.00	241,516,000.00	5,752,600.00	98.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,082,307,000.00	43,662,902,848.90	419,404,151.10	99.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,055,540,600.00	43,639,145,316.80	416,395,283.20	99.0
Даатгалын үйлчилгээ	9,531,800.00	9,529,667.10	2,132.90	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	4,324,900.00	1,619,965.00	2,704,935.00	37.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	6,842,600.00	6,842,600.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,765,300.00	5,765,300.00	-	100.0

Газрын төлбөр	301,800.00	-	301,800.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	16,145,900.00	15,177,460.00	968,440.00	94.0
Бараа үйлчилгээний бусад зардал	5,311,700.00	4,700,460.00	611,240.00	88.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,834,200.00	10,477,000.00	357,200.00	97.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,615,800.00	18,351,000.00	1,264,800.00	94.0
Бусад урсгал шилжүүлэг	19,615,800.00	18,351,000.00	1,264,800.00	94.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,615,800.00	18,351,000.00	1,264,800.00	94.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	46,572,159,700.00	45,891,334,243.43	680,825,456.57	99.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,553,459,700.00	45,870,091,390.43	683,368,309.57	99.0
Улсын төсвөөс санхүүжих	46,553,459,700.00	45,870,091,390.43	683,368,309.57	99.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	18,700,000.00	21,242,853.00	(2,542,853.00)	114.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,700,000.00	21,242,853.00	(2,542,853.00)	114.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20,934,008.00	(20,934,008.00)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	77	77	-	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	38	38	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	37	37	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38	38	-	100.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	31	31	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,143,873,932.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,339,461,642.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		980,823,441.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		256,742,818.67
210101	Үндсэн цалин		256,742,818.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		29,375,826.12
210201	Тэтгэврийн даатгал		29,375,826.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		15,120,000.00
210304	Байрны түрээс		15,120,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		42,052,198.00
210401	Бичиг хэрэг		5,657,925.00
210402	Тээвэр, шатахуун		27,296,342.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		5,878,594.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,219,337.00
2105	Нормативд зардал		5,043,390.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		5,043,390.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		30,142,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		20,745,600.00
210602	Тавилга		9,397,100.00
2107	Томилолт, зочны зардал		96,277,440.00
210701	Гадаад албан томилолт		31,755,440.00
210702	Дотоод албан томилолт		64,522,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		465,617,169.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		463,267,169.00
210803	Даатгалын үйлчилгээ		1,690,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		660,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		40,451,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		98,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		40,353,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		358,638,201.06
2132	Бусад урсгал шилжүүлэг		358,638,201.06
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		30,000,000.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		328,638,201.06
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,804,412,290.00
	Дотоод эх үүсвэрээр		1,804,412,290.00
222001	Тоног төхөөрөмж		1,804,412,290.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		3,143,873,932.85
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,143,873,932.85
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		3,089,792,133.85
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		54,081,799.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 1,878,435.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдэл, аудит хийсэн тайлангийн эцсийн үлдэгдлээс багаж, техник хэрэгсэл, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж болон биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлын дүнгээс нийт 369,294.90 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.	1	369,294.9			1	369,294.9	1	369,294.9				
Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт цэвэр мөнгөн гүйлгээний дүн 324,893.2 мянган төгрөгөөр Санхүү байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн дүнгээс зөрүүтэй илэрхийлсэн.	1	324,893.2			1	324,893.2	1	324,893.2				
Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангийн элэгдлийн дүнгээс 153,542.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.	1	153,542.3			1	153,542.3	1	153,542.3				
Санхүүгийн үр дүнгийн тайланд Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал дансны дүнг 104,418.8 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн.	1	104,418.8			1	104,418.8	1	104,418.8				
Нэмэлт санхүүжилтийн тайлангийн бусад урсгал шилжүүлгийн дүн (20,340.0)	1	20,340.0			1	20,340.0	1	20,340.0				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

мянган төгрөгийн сөрөг утгатай тайлагнасан.												
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 645,335.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	645,335.8			1	645,335.8	1	645,335.8				
Өмчийн өөрчлөлтийн тайланд тусгасан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралтын 251,610.3 мянган төгрөгийн хөрөнгө нь ТӨБЗГ-ын үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай тогтоолоор 66 нэр төрлийн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон байгаа тул Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар журмын дагуу СҮДТ-ын үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрүүлэн залруулав.	1	251,610.3			1	251,610.3	1	251,610.3				
Дүн	7	1,878,435.2			7	1,878,435.2	7	1,878,435.2	-	-	-	-

3.2 Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 688,427.2 мянган төгрөгийн 10 зөрчил² илэрснээс, 205,710.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 399,195.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлж, 83,521.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Томилолтын зардлыг бодит гүйцэтгэлээс 1,010.45 мянган төгрөгийг илүү тооцож, томилолтоор явсан ажилчдаас хоол, унааны мөнгө 652.0 мянган төгрөгийг дутуу суутгаж, нийт 1,662.45 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	1,662.5	1	1,662.5									
Ойжуулалт хөтөлбөр болон Афоко төслөөс гэрээгээр ажил гүйцэтгэсэн 41 ААН байгууллагын гэрээний тусгай нөхцөлд 1-2 жилийн хугацаанд гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх чанарын баталгааг байршуулахаар тусгасан боловч нийт 204,047.8 мянган төгрөгийн чанарын баталгааг барьцаа дансанд төвлөрүүлэлгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон байна.	1	204,047.8	1	204,047.8									
Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, бусад холбогдох	1	89,850.0			1	89,850.0							

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<p>хууль тогтоомжийн төсөл боловсруулж батлуулах, хэлэлцүүлэг зохион байгуулах арга хэмжээг шууд худалдан авалтын үнийн дүнд багтаан 5 иргэн, ХХН-тэй гэрээ байгуулж, нийт 89,850.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.</p>												
<p>Бараа материалын дансанд бүртгэлтэй 3 нэр төрлийн 36,870.0 мянган төгрөгийн ном агуулахад хадгалсан хугацаа тодорхойгүй, их хэмжээгээр нөөц бүрдүүлэн ашиглалтгүйгээр хураасан, бараа материалын нэршил тодорхойгүй, нэг нэршлээр олон хөрөнгүүдийг орлогодсон, жилийн эцсийн тооллого хийж тооцоо бодсон баримтгүй, бараа материалын бүртгэл, мэдээлэл дутмаг зэрэг зөрчлүүд байна.</p>	1	-			1	-						
<p>Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогоор нийт 81,886.9 мянган төгрөгийн хөрөнгө биетээр байхгүй байна. Үүнд: 1. Тус байгууллагын хөрөнгөнд бүртгэлтэй Завхан аймгийн Байгаль орчны газрын Ойн нэгжид 2016 онд түр ашиглуулахаар өгсөн 12-79 УНЭ улсын дугаартай 57,215.1 мянган төгрөгийн өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, "Тоёота Ланд Круйзер 105" маркийн автомашин хариуцах эзэн тодорхойгүй, олдохгүй болсон.</p>	1	81,886.9			1	81,886.9						

<p>2. Захиргаа, удирдлагын хэлтсийн даргын эзэмшиж буй эд хөрөнгөд бүртгэлтэй 2,121.8 мянган төгрөгийн Dell маркийн компьютерын процессорыг Эрүүгийн цагдаагийн газраас 2023.05.03-нд авч яваад алга болсон, хөрөнгө биетээр байхгүй байна.</p> <p>3. Нэг бүр нь 4,510.0 мянган төгрөгийн өртөгтэй 5 ширхэг, нийт 22,500.0 мянган төгрөгийн хөрөнгө дутагдсан.</p> <p>4. Санхүүгийн программд үндсэн хөрөнгийг бүртгэхдээ хөрөнгийн загвар, нэр, төрөл, байршил, хариуцах эзэн болон хөрөнгөтэй холбогдох мэдээллүүдийг хөтлөөгүй, ижил нэршлээр мэдээлэл дутуу кодлон бүртгэлжүүлсэн ба Сүхбаатар дүүргийн Дамбадаржаа дахь "Модлог ургамлын цэцэрлэгт хүрээлэн"-д байрлах хөрөнгийн агуулахад тайлант онд шинээр худалдан авсан хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналт хангалтгүй, мөн олон жил болсон ашиглагдахгүй, хөрөнгийн үлдэгдэлтэй байна.</p>											
<p>Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй нийт 806,255.7 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, дансны үнийг шинэчлэн тогтоох ажлыг хэрэгжүүлээгүй байна.</p>	1	-			1	-					

<p>Ойн газрын даргын 2024 оны А/87 тоот тушаалаар тэрбум мод тарьж, арчлан ургуулах чиглэлээр 1000 сургагч багш бэлтгэх ажлын хүрээнд 195,902.2 мянган төгрөгийн төсөв батлан Монгол улсын их сургуультай 178,362.8 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулан 498 иргэнийг сургагч багшаар бэлтгэх сургалтад хамруулсан, сургалтад хамрагдсан иргэдийн сонгон шалгаруулалт, сургагч багш нарын гүйцэтгэсэн ажлын тайлан хангалтгүй, сургагч багш бэлтгэснээр гарах үр дүн нь тодорхойгүй байна.</p>	1	195,902.2			1	195,902.2						
<p>Тендерийн баримт бичигт гэрээний үнийн дүнгийн 3 хувьтай тэнцэх гүйцэтгэлийн баталгаа, 5-10 хувьтай тэнцэх чанарын баталгаа байршуулна гэж заасан боловч гүйцэтгэлийн баталгааг гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх мөнгөн дүнгээр байршуулсан Ойжуулалт хөтөлбөрийн 4 ААН байгууллагын 4,569.0 мянган төгрөг, Афоко төслийн 2 ААН байгууллагын 26,986.9 мянган төгрөг, нийт 31,555.9 мянган төгрөгийн гэрээнд тусгасан гүйцэтгэлийн баталгааг илүү хувиар байршуулан санхүүжилтийг бүрэн олгосон байна.</p>	1	31,555.9			1	31,555.9						
<p>Мод сөөг тарьцын журмын төсөл боловсруулах болон Үрийн</p>	1	24,500.0					1	24,500.0				

лабораторийн итгэмжлэл авах зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг гүйцэтгэх нэр бүхий 2 компанитай гэрээ байгуулан нийт 35,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн урьдчилгаа 70.0 хувь буюу 24,500.0 мянган төгрөгийг шууд зардлаар хүлээн зөвшөөрч, тайлагнасан байна.												
Ойн газраас БОУАӨС-ын орон тооны бус зөвлөх, яамны ахлах мэргэжилтэн, Хөгжил академи болон СОР17 ажлын албаны нэр бүхий албан хаагчдын гадаад томилолтын зардалд 59,021.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	59,021.9					1	59,021.9				
Дүн	10	688,427.2	2	205,710.3	6	399,195.0	2	83,521.9	-	-	-	-

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар нийт 269,198.6 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш цалингийн зардлаас бусад үнийн дүн бүхий орлогын 137,481.2 мянган төгрөгийн 2 гүйлгээ, зарлагын 131,717.4 мянган төгрөгийн 14 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.	1	269,198.6	1	269,198.6		
Дүн	1	269,198.6	1	269,198.6	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Ойн газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй авто тээврийн хэрэгсэл нь бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар ашиглаагүй байна.	1	-			1	-
Өмнөх аудитаар өгсөн байгууллагын тусгай хэрэгцээнд ашиглах газрыг зориулалтын дагуу ашиглах, маргаантай газрын асуудлыг хуулийн байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, тусгай хэрэгцээнд ашиглах газрыг 1 иргэн чөлөөлсөн ба үлдсэн 14 иргэн газрын маргаантай, бүрэн чөлөөлөөгүй байна.	1	-	1	-		
Санхүүгийн тайланд бүртгэлтэй авто тээврийн хэрэгсэл нь авто тээврийн хэрэгслийн ашиглалтын хувийн хэрэгт тухайн тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоо, засвар үйлчилгээний мэдээллийг хөтөлж хэвшээгүй байна.	1	-			1	-
Дүн	3	-	1	-	2	-
Нийт дүн	4	269,198.6	2	269,198.6	2	-